2021 оны 04 сарын 15-ны өдөр Дугаар А/287 Улаанбаатар хот

Захирамжид өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/155 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 1, 2, 3, 18-т заасан төсөл, арга хэмжээнд оруулсан өөрчлөлтийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцсэнийг үндэслэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захирамжийн хавсралтын 1, 2, 3, 4-т заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, 5-т заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Мэдээлэл технологийн газар (О.Чинзориг)-т, 6, 7, 8-т заасан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Авто замын хөгжлийн газар (Г.Баярсайхан)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар (М.Баяраа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
4 дүгээр сарын 15-ны өдрийн
А/287 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ А/155 ДУГААР ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТААР БАТЛАГДСАН “НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ”-ЫН 1, 2, 3, 18-Т ЗААСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖАГСААЛТ

(сая төг)

№	Өөрчлөх төсөл, арга хэмжээ	Хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн	Өөрчлөлт оруулсан төсөл, арга хэмжээ	Хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1	Чийрэгжүүлэлтийн талбай /БГД, 12 дугаар хороо/	2021	100.0	100.0	Хорооны байр орчмын тохижилтын ажил (БГД, 11 дүгээр хороо)	2021	60.0	60.0
2					14, 15 дугаар байруудын хүүхдийн тоглоомын талбайн тохижилт (БГД, 12 дугаар хороо)	2021	55.0	55.0
3	Нийтийн ахуй үйлчилгээг сайжруулах /БГД, 16 дугаар хороо/	2021	100.0	100.0	Туулын 8 дугаар гудамж орчмын тохижилтын ажил (БГД, 16 дугаар хороо)	2021	60.0	60.0
4					"Бат-Оршил" СӨХ-ны талбайд ногоон байгууламж, гадна талбайн тохижилт (БГД, 18 дугаар хороо)	2021	55.0	55.0
5	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт /БГД, 23	2021	100.0	100.0	Камержуулалт (БГД, 16 дугаар хороо)	2021	40.0	40.0

№	Өөрчлөх төсөл, арга хэмжээ	Хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн	Өөрчлөлт оруулсан төсөл, арга хэмжээ	Хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
6	дугаар хороо/				Нийтийн эзэмшлийн авто зогсоол (БГД, 11 дүгээр хороо)	2021	40.0	40.0
7	Авто зогсоол /БГД, 18 дугаар хороо/	2021	100.0	100.0	14, 15 дугаар байруудын дунд авто зогсоол (БГД, 12 дугаар хороо)	2021	45.0	45.0
8					45 дугаар байрын өмнө авто зогсоол (БГД, 18 дугаар хороо)	2021	45.0	45.0
	ДҮН		400.0	400.0	ДҮН		400.0	400.0